



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/596

Булган сум

**Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль
зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3 дах заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Булган аймагт 2025 оны 09 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-д шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг дэг журам, сахилга хариуцлагатай зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Н.Хишигдорж)-д үүрэг болгосугай.

3. Шаардагдах зардал 14,850,000 (арван дөрвөн сая найман зуун тавин мянга) төгрөгийг аймгийн 2025 оны батлагдсан төсвийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР



6325010819

Аймгийн Засаг даргын даргын
2025 оны 09 дугаар сарын 22- ны өдрийн
А/С/26 дугаар захирамжийн хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬД ЗАРЦУУЛАХ
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ /төг/	Тайлбар
1	2	3	4
1	Хоол	14,850,000	3 өдөр*110хүн*45,000төг=14,850,000
Нийт дүн			14,850,000